

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

20 *24* оны *12* сарын *09* ны өдөр

№ *32*

Улаанбаатар хот

### *Арилжааны банкнаас зээл авах зөвшөөрөл олгох тухай*

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, “Сэндли ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6.29 дэх заалтыг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас **ТОГТООХ нь:**

1. Банк бус санхүүгийн байгууллагын харилцагчдад зээл олгох, зээлийн эрэлтийг хэвийн хадгалах, бизнес төлөвлөгөөний хүрээнд “Сэндли ББСБ” ХК-ийн нэр дээр М банкнаас эргэлтийн хөрөнгийн зээлийг дараах нөхцөлөөр авахыг зөвшөөрсүгэй.

Зээлийн эрхийн хэмжээ: 7,500,000,000 /долоон тэрбум таван зуун сая/ төгрөг

Зээлийн эрхийн хугацаа: 12 /арван хоёр/ сар

Зээлийн хүүгийн хэмжээ: жилийн 20 /хорь/ хувь

2. Энэхүү тогтоолын 1-д заасан “Сэндли ББСБ” ХК-ийн зээлийн үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор 15 /арван таван/ тэрбум төгрөгийн дүн бүхий хэрэглээний, үл хөдлөх хөрөнгө болон автомашин барьцаалсан зээлийн багцыг барьцаалуулахыг зөвшөөрсүгэй.
3. Банктай зээлийн болон барьцааны гэрээ байгуулах, гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал /Б.Одгэрэл/, Үйл ажиллагаа хариуцсан захирал /Б.Ичинхорлоо/ нарт олгосугай.
4. Зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулж ажиллахыг Эрсдэл хяналт, шалгалт хариуцсан захирал /Д.Баярбат/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА  
Б.НАРАНБАТ

